

Сайн байна уу. Намайг Сайханаа гэдэг.

Шинэ зүйлд суралцаж, орчин цаг үетэйгээ хөл нийлүүлэн алахыг хүсдэг нэгэн ээж байна. Японд нөхөр, хоёр охины хамт амьдардаг. Бид бүгд л маш завгүй амьдралаар амьдардаг. Завгүй гэдгээ шалтаг болгоод байвал хэзээ ч өсөж хөгжихгүй юм байна, алдсан ч оносон ч шинэ зүйл эхлүүлээд үзье гэсэн маань алдаа байгаагүй. Шинээр сурсан зүйлүүдийн нэг бол вэбсайт угсарч сурсан явдал байлаа. Ийнхүү шинэхэн хуудсаараа та бүхэнтэйгээ уулзаж байгаадаа баяртай байна.

Дижиталын эринд хөл тавьмаар, онлайнаар орлого олох аргад суралцмаар байвч эргэлзээд, шийдэж чадахгүй байна уу?

Үнэхээр орлого олдог гэж үү, луйвар биш байгаа

Би англи хэл сайн биш, угаасаа чадахгүй

Олны өмнө гарна гэж бүтэхгүй гэх мэтээр бид өөрсдийгөө хайрцагладаг. Би ч адилхан тийм байсан.

Бид өөрсдийгөө юу бүтээж, хаана хүрч чадахыг мэдэхгүй.

Гар утас, компьютер ашиглан хүссэн газраасаа интернэт л байвал орлого олж болдог эрин зуунд бид амьдарч байна.

Боломжийг ашигла, алдахаас бүү ай

Хүс, хий, бүтээ, үр дүн үз

Хамгийн тохиромжтой цаг хугацаа бол яг одоо л байдаг